

VII. Дуртгал, дурсамж, шүүмж

ДИВААЖИНТАЙ ТӨРСӨН НУТАГ МИНЬ

(Дурсамж, тэмдэглэл)

Д.Лувсан

Эхээс төрж энэ дэлхийн хэвлий газар шороотой хүйн холбоо залгаж, үйлж унаж, инээж боссон газар нутаг минь Түшээт Хан аймгийн Дайчин Чин Вангийн хошуу, Вангийн хүрээний газар шороо гэж бодоход сэтгэл өөг байдаг. Энэ нь ар Халхын алдартай хүрээ хийдийн анхны хошууны нэг юм. Дайчин Вангийн хүрээ нь 400 орчим жилийн түүхтэй, Монгол дахь шарын шашны анхны хүрээний нэг бөгөөд Эрдэнэ зуугийн дараа ордог байжээ. Унасан газар, угаасан ус, төрсөн газар нутгаа хайрлаж бахархдаг нь хүн бүхний сэтгэлийн увьдис билээ. Булган хангай уулыг түшсэн нутагтаа очиход сэтгэл баясан, нүдэнд нулимс хурж, самсаа аргах шиг болдог. Арга ч үгүй биз дээ. Аав, ээж минь амьдарч, ах эгч маань өсөж торнисон өлгий нутаг минь шүү дээ.

Ер нь хүний төрсөн нутаг юутай ч зүйрлэмгүй сайхан санагддаг учир амьдралынхаа туршид тулж түшдэг нөмөр нөөлөгтэй шүтээн гэж надад бодогддог.

Булган хотын зүүн өмнө орших Мээж хайрханы дээгүүр өглөөний алтан шар нар уулын цаанаас ургахдаа эхлээд Булган хангай, Хан жаргалант, Шар чулуут, Ачуутын гозгор уулсын энгэрт элчтэй гэрлээ тусгахад хээр талд шинэ өдөр эхэлж, шувууд жиргэн, хангай нутгийн чийгтэй хөрсний ургамал ногоо, цэцэгс өнгөө сэргээхэд ариухан тансаг үнэртэй агаар мэдрэгддэг. Ийнхүү Булган хотын нэгэн өглөө эхэлж хүн зоны ажил хөдөлмөр, сургууль соёлын ажил ид буцалж эхэлдэг, Би Булган хангай нутгийнхаа Вангийн хүрээний шашин шүтээний гайхамшигтай цогцолбор түүхт дурсгалын бүтээлийн багахан хэсгийг түүх сударт бичин үлдээснийг энэ сэдэвт бичлээ. Энэ нь эрдэм номын мөр хөөсөн судлаачид, оюутан залуус, сэтгэлдээ хайрлаж өхөөрдөж суудаг үр хүүхэд, ач зээ нар минь сонирхон уншиж таньж мэдэх болов уу гэж бодох юм.

• Нутгийн настан буурлууд Булганчууд бурхан шүтээнээ хүндэлдэг, буян хишиг ихтэй, будаа тариа, түүх домог арвин нутагтай хүмүүс гэж ярьж байхыг сонсож байсан билээ. Буун дуу тачигнуулж, ардын хувьсгалын их үйл хэрэгт зүтгэж явсан 100 гаруй партизантай. Тэдний төв штаб нь байрлаж байсан үзэмж сайтай хөх тоосгон байшин одоо партизануудын музей болон үлджээ. Улсын болон ХАА-н анхны хөдөлмөрийн баатар, ардын ба сансрын ууган нисэгч, соёл урлаг, шинжлэх ухааны зүтгэлтэн, ардын зохиолч зэрэг анхдагчууд Булган нутгаас төрсөн.

Олноо өргөгдсөн Монгол улсын Гадаад яамны сайд Халх Монголын эх оронч Чин ван Ханддорж, ардын хувьсгалын манлай баатар Магсаржав, домогт жанжин улсын баатар Лхагвасүрэн, гарамгай баатар Дандар, Хоньчин баатар Очир, уурхайчин баатар Даваажав, төрийн зүтгэлтэн зохиолч С.Удвал, шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, академич Ж.Болдбаатар зэрэг гэгээн оюунлаг хүмүүсийг дурдахад бардам, сэтгэл өөг байдаг.

Түүх, нийгмийн талаас халхын эх оронч, яруу найрагч Цогт хунтайж 1581 онд Булган аймгийн Дашинчилэн, Бүрэгхангай сумын зааг тунгалаг Туулын сав нутагт төрж өссөн уугуул нутгийн суурь нь одоо байдаг бол бөх судлаач Ж.Дамдингийн судалгаагаар Түшээт Хан аймгийн Дайчин Чин Вангийн хошуу одоогийн Сайхан сумын Шагдарын Намхай аварга халхын долоон хошуу даншиг, арван засгийн наадам зэрэг улсын чанартай том наадмуудад 26 удаа түрүүлж, 5 удаа үзүүрлэж байжээ. Ийм олон жил дараалан барилдахдаа

түрүүлж үзүүрлэсэн бөх түүний өмнөх алдартай бөхчүүдээс гарч байгаагүй гэсэн. Намхай аварга бие чилээрхүү үедээ Богдод мөргөхөөр ирэхдээ 1908 онд Даншигт үзүүрлэн 10 засагт түрүүлж, насан өөд болсон үнэхээр босоо бөх гэж яригддаг байсан. Одоо ч Булган хангай нутгийг их хүчтэн бөхийн нутаг гэдэг ч үнэн шүү.

Спорт, бөх судлаач эрдэмтэн Ц.Бат-Очир, Л.Хайдав, Ж.Болдбаатар нар “Эрийн гурван наадам”, “Монгол бөх 70 жил”, “Дайчин Вангийн домогт хүчтэнүүд” зэрэг ном зохиолууддаа монгол бөхийн түүхэнд урьд хожид гараагүй гайхамшигт энгүүн их хүчтэн Намхай аварга, ах дүү алдарт аварга Лувсанжамба, Даншигийн арслан хулгар Нацаг, мундаг Лувсандаш, заан бүрхэг Дэндэв, Пүрэв нарыг сорчлон оруулсан бол Дайчин Чин Вангийн хошуунаас төрсөн Даншигийн 35 цолтон, ардын хувьсгалын жилд төрсөн их аварга Б.Түвдэндорж, С.Цэрэн, тэмээ өргөдөг Б.Жамъяндорж, улсын заан И.Доржсамбуу, начин Ж.Оргилболд хүртэлх улсын 65 цолтны тухай дэлгэрэнгүй бичсэн байдаг.

УБИС-ийн багш С.Хөвсгөлийн Дайчин Вангийн хүрээний гурван гайхамшиг гэдэг тэмдэглэл бичсэнийг олж үзээд ихэд баярлан олзуурхаж үр хүүхэд, ах дүү, танил олондоо тэр тухай бичиж сонирхуулахыг бодсон юм. Учир нь хөгшин буурал миний бага насны он жилүүд Дайчин Вангийн хүрээний газар шороон дээр өнгөрсөн билээ. Нар салхинд борлосон бор жаалууд тэр гайхамшгуудыг ихэд сонирхон үзэж, хувраг, лам нарт хөөгдөж байхдаа мөргөлчин, сүсэгтэн олон хэрхэн биширч мөргөл үйлдэж байсныг мэдэх юм. Вангийн хүрээний шашин мөргөлийн тэр уран барилга, түүх соёлын гайхамшигт бүтээл монгол орныг хамарсан их хэлмэгдүүлэлтийн он жилүүдэд нурж, устгагдаж одоо зөвхөн эвдэрхий хэсэг туурь үлдсэнийг харахад үнэхээр харамсалтай байдаг. Түүнийг эвдэж нурааж байхад нутгийн сүсэгтэн олны сэтгэл яаж зовж шаналж байсан бол гэж одоо бодоход зүрх сэтгэлээсээ тэр үеийн хүмүүсийг хайрладаг юм.

1979 онд 14-р далай лам Данзанжамц Монголд айлчилж ирээд Вангийн хүрээгээр орох юмсан. Тэнд 1905 онд 13-р далай ламын аравнайлсан өндөр цагаан суварга байх учиртай, бас бурханы орон Диваажин, Наян тохой Майдартай сүм бий гэсэн энэ гурвыг үзэх юмсан гэж ихэд бишрэн шашны зүтгэлтнүүдэд ярьсан гэнэ лээ гэж шашин номын газраас сонссон хүний ам дамжсан яриа байдаг. Энэ яриа чухамхүү үндэслэлтэй байж болох юм.

Вангийн хүрээ

Хуучны Вангийн хүрээ нь одоогийн Булган аймгийн төвийн урдахь Тамгын толгойн өмнө талд мөн ч сайхан байрлалтай шашин номын төв байсан. Тэнд бурхан номын уншлага бясалгалын их ажил явагддаг байсан. Тэр үед бурхан мөнхөд оршдог гэж хүн бүхэн ойлгодог байжээ. Ер нь бурхдыг сэтгэлээрээ мөнхлөн сүсэглэн биширч явбал хүн төрсөн цагаасаа төрөл арилжих хүртлээ аливаа саад, гай тогтор аюул бүхнээс агижран холдож, амьдралын сайн сайхан заргалын дээдийг эдлэхэд бурхан шашин хүмүүсийн сэтгэлийг байнга ариусгаж тусалж байдаг гэсэн ухамсар хүмүүсийг оюун санаанд шингэж чадсан байсан даа.

Тэр үед Нийслэл хүрээнээс ирэх тээврийн бүх хөсөг Орхон голын гүүрээр гараад гүвээ толгодын дундуур явж, Цэцэгт толгой дээгүүр гарч Вангийн хүрээний дундуур явж одоогийн аймгийн төв ордог байв. Энэ замаар Вангийн хүрээний суурин хоёр хуваагдана. Баруун хэсгийг хүрээ хийдийн тал, зүүн хэсгийг хороо харчуудын зах зээл тал гэнэ. Хүрээ талд дугана, сүмүүд, Гэсэрийн сүм, суврага, хувраг лам нарын хашаа байшин байрлана. Зүүн хэсэгт Монгол, Орос, Хятад иргэдийн худалдаа наймааны дэлгүүр, пүүс, харилцаа холбоо, хүн эмнэлэг, нутгийн хятад иргэдийн ногооны их газар байж билээ.

Ногооны газрыг усалдаг ус нь маш сонин байрлалтай. Ачуутын голыг боож аймгийн баруун талын өндөр гүвээ толгойн энгэрээр өгсүүлэн татсан шуудуугаар усыг нь урсгаж, Тамгын толгой дээгүүр гарч зүүн талын зах зээл, ногооны их хэмжээний талбайг усалдагсан. Голын усыг өндөр гүвээ толгойн бэлээр өгсүүлэн татсан шуудуугаар урсган авч байсан нь одоо харахад хэн бүхэнд тун сонирхолтой. Энэ нь хятад иргэдийн амьдрах ур ухааны бүтээл юм даа. Олон жилийн өмнө нутагтаа ажлаар явж байхдаа яамныхаа хүнд ярихад:

- Ээ арайч дээ энэ голын усыг тэр өндрөөд өгсүүлэн урсгах гэж яаж байхав" гэхээр нь дагуулж очоод үзүүлэхэд үнэхээр бишрэн гайхаж байсансан.

Түшээт Хан аймгийн Дайчин Чин Вангийн хошууны төв Дайчин Чин Вангийн хошууны төв Дайчин Вангийн хүрээ нь (хожим Дайчин Чин Вангийн хүрээ гэх болсон) тэр үеийн Да хүрээний дараа орох халхын том хүрээ байлаа. Томоороо Санбээсийн хүрээтэй эн зэрэгцэж байжээ. Гандан тэгчилэн хийдэд 1000 гаруй лам хуварга байсан бол Вангийн хүрээнд 500 гаруй байсан гэж багадаа тус хийдэд шавилан сууж байсан миний аавыг сайн таних шашны сургуулийн багш асан, урлагийн гавъяат зүтгэлтэн Д.Данзан ламтан гуай хуучилж байсан. Дайчин Вангийн хүрээ нь XVII зууны II хагаст үндэслэн байгуулагдсан бөгөөд 12 аймагтай, 30 дугантай хамгийн том нь Чогчин дуган юм. Түүний жасыг хариуцсан лам нь миний аав Төрийн Чойжамц гэж байсан. Нярав хүн тэр дуганы засвар, бүх үйлчилгээ, мал, хөрөнгийг хариуцаж, манж цав хийхэд хэрэглэх сүү, цагаан идээ, мах, айраг зэрэг хоол хүнсний бэлтгэлийг хангадаг. Ийм хүнийг жасын нярав гэдэг. 1930-аад онд тус хүрээнд зээрэмбийн дамжаа барьж байсан Дугаржав гуай 1992 оны нэгэн ярилцлагадаа:

Вангийн хүрээний Цогчин дугана нь 1685 онд баригдсан 3 давхар, 64 баганатай, 34 хаалгатай, их шүтээн байсан. Жил бүрийн зуны адаг сарын 9-нд Цогчин дуганы үүдэнд Догшин улаан сахиус Жамсран, Махгал бурхан, Гомбо, Эрлэг номун хаан Дамдинчөөжөө зэрэг том бурхдын багтай 110 орчим цам харайлт бүжиг болж Майдар эргэдэг байсан гэжээ.

Ер нь Монголд шарын шашин үүссэнээс хойш XVII зуунаас эхлэн энэ ёслол үйлддэг болсон гэдэг. Цам харайлт нь тэр жилдээ хамаг олны буян заяаг тэгшитгэж, урт настай, удаан жаргалтай явах, дайн самуунгүй, энх амар амгалан, эв найртай амьдран жаргах, тэр жилийн муу барцдыг хөөн зайлуулах зан үйлтэй байжээ. Цам бүжгийн эхэнд өглөгийн эзэн урт цагаан сахалтай цагаан баг хувцастай Хашин хаан багтай хүүхдүүдээ дагуулан гарч ирж түмэн олныг бясгадаг байсан. Энэ бүхэн нь дэлхийн урлагийн соёлд өргөсөн монголын урлагийн дээж учир одоо соёлт хүмүүс маш их сонирхдог. Вангийн хүрээний Цогчин дуганыг төв халхад хамгийн томд орох модон барилгын гайхамшигт дурсгал, шашны уран барилгын цогцолбор гэж хэвлэлд бичсэн байдаг.

Их дацан хийдийн дэргэд шашны боловсрол олгодог сургуультай байжээ. Энэ сургууль нь 4 зүйлийн мяндаг /мэргэжил/ олгодог байснаар Богдын хүрээний гандан хийдээс илүү байсан гэдэг.

Вангийн хүрээнд: Гавж-гүн ухааны зэрэг, Аграмба-тарьны ухааны зэрэг, Маарамба-эмнэлгийн ухааны зэрэг, Зээрэмбэ-зурхайн ухааны зэрэг олгодог байсан бол Гандан хийдэд гавж, маарамбын зэрэг л олгодог байжээ,

Вангийн хүрээний тус хийдийн Аграмба Дандар гуайг гүн ухаан, анагаах ухааны олон ном бичсэн тухай БНМАУ-ын түүхэнд дурдсан байдаг. Ийнхүү Вангийн хүрээ нь Монголд шашин, шинжлэх ухаан, соёлын том төв болж байсан төдийгүй уран барилга, соёлын дурсгал болох хэд хэдэн онцгой бүтээлээрээ алдартай. Их хэлмэгдүүлэлтин жилүүдэд Вангийн хүрээний лам нарыг баривчилж дуусаад дугана, сүмийг эвдэж нураан тонож дээрэмдсэн. Буян номтой лам нарыг ЗИС-5 машинд чихэж суулгаад даавуу бризентээр

бүтээж урд талд нь буутай хоёр цагдаа зогсоод Сэлэнгэ аймаг руу хөдөлнө. Үүнийг харсан эмээ, өвөө нар сүүнийхээ дээжийг өргөн залбирч хоцордог байв. Харин Цогчин дуганыг нураалгүй үлдээж трактор, машин хийдэг граж болгосон байсныг сайн санаж байна. 1937 онд манай аймагт МАА-н машинт тракторын станц байгуулагдсан юм. Би хүүхэд ахуй насаа энэ нутагт өнгөрүүлсэн тул цуглуулж хадгалсан хэвлэлийн хуудсуудыг ашиглаж, үзэж харж, ухаа санаандаа тогтоосноо нэмэрлэж Вангийн хүрээний гурван гайхамшгийн туха бичье гэж бодсон юм.

Нэг. Диваажин

Диваажинг 1877 онд баригдсан гэдэг. Вангийн хүрээний баруун тал, Майдарын голын хаялга захад мод ургамал ихтэй маш сайхан хиймэл жижиг уулан дээр баригдсан сүм байсан. Сүм нь алтан дээвэртэй, 8-н талтай, тал бүр нь гэрэл гэгээ туссан шилэн цонхтой. Энэ сүмд диваажингийн орныг урла үзүүлсэн байдаг. Уулын урд талд нь тулгаж барьсан дугантай. Дуган дотор лам нар хоёр эгнээгээр жавдаалан сууж номоо уншдаг. Мөргөлчид адис авч уулы шатаар дээш гарч мөргөл хийдэг.

Шатаар гарахын өмнө хаалганы хоёр талын хананд амьд ахуйдаа бурхан багшаа шүтэж мөргөж бусдад тусалж буян хийж байсан нь бурханы орсон диваажинд төрж жаргах, хилэнц нүгэлтэй нь тамд унаж цээрлэл үзэхийг харуулсан зураг байдаг байсан. Буянтай хүмүүс ингээд бурханы орсон диваажинд очдог гэж орхимжоо хийсгэн нисэж яваа лам нарыг заагаар тайлбарладаг. Харин эцэг эх, ах дүүсээ хүндлэхгүй шоолж, элэглэж байсан бол хэлийг нь цоолж аргамжаар татаж гаргаад анжсаар хагалж тариа тарьж байгаа амьтан хүн тамлаж амийг нь хороож нүгэл хийсэн бол дүрэлзсэн галтай буцалж байгаа устай тогоонд оруулж байгаагаар зурсан байдгийг тод санадаг юм. Диваажинг тойрч, Майдарын гол урсдаг, уулын эргэн тойронд хар мод, нарс, хуш, гацуур, бургас зэрэг мод тарьсан, самар, мойл, үрэл, нэр, гүзээлзгэнэ, аньс зэрэг жимс янз бүрийн цэцэгс алагласан түүнийг хамгаалсан модон хайстай маш үзэмжтэй газар байж билээ. Нутгийн жаахан хүүхдүүд бишрэх хурга ишгээ зориуд оруулж самар жимсийг нь түүж их л хөөгдөж загнуулж байдагсан. Эцэг, эх ч алганы амт үзүүлнэ.

Диваажингийн дотор түүний их эзэн Авид буюу Одогмэд бурханы орны дүрслэн хийсэн төв дунд нь бурханы баримал дүрсийг үүлэн дээр сууж буй маягаар дээврээс унжуулан шалнаас хөндий тогтоож, түүнийг тойрон наймаа Бодисадва хүрээлснээр хийсэн байжээ. Тэрчлэн Авид бурханы амнаас гэрэл цацарч буйг маш гоё гялгар эдийг солонгын маягаар байрлуулан дүрсэлж дуганы таазыг хать гэдэг хоргойн төрлийн гялгар торгоор доторлосон бөгөөд нисэж яваа хүний модон дүрсүүдийг таазнаас дүүжилсэн байж билээ. Мөн хангай уул, түүний гол мөрөн, ой мод, тэнд амьдарч буй төрөл бүрийн амьтад, жигүүртэн шувуудыг мяндсан утас, шил ваараар өнгө алаглуулж бүтээснийг харсан сүсэгтэн олонд бурханы номд сүсэглэн буяны мөр хөөврийм диваажинд очин ингэж жаргана гэж төсөөлөн дүрсэлж үзүүлсэн бурханы номыг сурталчилсан газар байсан.

Энэ нь урчуудын маш гоёмсог бүтээсэн хүмүүсийг сүсэглэ бишрүүлэхээс гадна аргагүй л гоо сайхны таашаал өгч байсан соёл урлагийн том дурсгал байж дээ. Өвгөн лам нарын яриагаар...

- Ийм диваажин Халхад л лав байхгүй. Энэтхэг, Төвдөд байж магадгүй гэхдээ биднийг явж байхад л лав таарч байгаагүй гэж ярьж байсан түүхтэй. Хэрэв өдийд байсан сан бол жуулчдын үзэх, мөргөх том төв байх байж дээ гэдэг бодогдоно. Ийм хосгүй гайхамшгийг сэтгэн зохиож бүтээсэн ур ухаантай эл өвгөдийнхөө нэр их хөдөлмөрийг бишрэх сэтгэл аргагүй л төрдөг юм. Ганд хийдийн гавж, урлагийн гавъяат зүтгэлтэн Д.Данзан гуай 1963 о

дываажингийн загварыг хийж, Булган аймгийн орон нутгийн музейд өгсөн байсан.

Хоёр. Цагаан суврага

Бурхан шашин урлах ухаанаар дүрслэгдэж бүтдэг. Урлах ухаан олон янз. Суварга бол түүний гол төрөл. Ертөнцийн хүмүүсийг буяны замд хөтөлж, сэтгэлийн ариусгалд дууддагаараа суврага бүтээх нь учиртай. Суварга бол амаг бурхдын хурах ордон мөн гэж бурханч лам Г.Пүрэвбат бичсэн. Ер нь цэлхийн олон оронд тохиолддог гол усны аюул, газар хөдлөлт зэрэг олон янзын амшиг, шуурганд суврага ганцаараа гэмтэлгүй үлддэг. Өндөр мод юмс дээр аянга бууж байхад харин суварган дээр аянга буудаггүй нь хүмүүсийг айхшруулдаг. Вангийн хүрээний Диваажингийн баруун талд Майдарын голын гурьд дэнж дээр Халхад алдартай өндөр цагаан суврага байдаг байсан. Энэ суврага нь 1905 онд бүтээгдсэн бөгөөд Халхад үүнээс өөр өндөр суварга байгаагүй. Одоо суваргын суурь л үлджээ. Үүнийг харахад уран барилгын гайхамшигт дурсгал байсныг гэрчилдэг. Суварга нь Буддын шашны номоор бол нэг ёсны хөшөө юм даа. Будда бурханы дурсгалд босгосон 8 төрлийн суварга байдгийн Бодь суварга гэгчийг томруулан хийсэн нь энэ байжээ. Энэ суваргыг 1905 онд барьж дуусгахад тэр үед /1905-1906 он хүртэл/ Вангийн хүрээнд гур сууж амьдарч байсан 13-р далай лам Лувсанжамц аравнайлан түүхтэй учир төвд газраас хүртэл мөргөлчид ирдэг байсан гэлцэнэ. Суварганы хэлбэр нь Эрдэнэ зууд байдаг Бодь суваргатай адил байжээ. Уран барилгын бүтээл эл суваргын суурийг тэгшилж өнгөлсөн боржин чулуугаар хийсэн. Боржин чулууны өрт нь 1,2 м, өргөн нь 50 см, өндөр нь 40см параллелолипед хэлбэртэй юм. Тадна талын ханыг маш нарийн өнгөлж зассан нь техник хөгжөөгүй байсан тэр үед ямар багажаар яаж ингэж зассан бол, тэр том чулуунуудыг яаж дээш нь гаргаа бол гэсэн асуулт гайхал төрүүлсэн. Уг суварга 40 гаруй метр өндөр гэхэд яаж бариа бол ёстой л ертөнцийн нөгөө долоон гайхамшгийн нэгд тооцогддог. Египтийн алдарт пирамидуудыг барьсантай адилдуу л юм болсон гэж бодогдох биз. Эдгээр боржин чулууг Шар чулуут, Ачуутын гозгор уулын өвөр Чандагатаас модон гүүр бариад үхэр тэргээр зөөсөн гэдэг. Саяхан болтол түүрний суурь бүдүүн шонгууд байсан гэж нутгийн иргэд дурсан ярьдаг.

Цагаан суварга нь суурьныхаа дунд орчимд өндөр дээр гэр мэт бумбатай. Бумбыг нь модоор хийгээд гөлмөн төмрөөр өнгөлсөн байжээ. Дороос нь харахад хоёр гөлмөн төмөр зэрэгцүүлээд өнгөлсөн хэсэг нь бага зэрэг дөрвөлжин юм шиг их л том харагдаж байсан гэж Д.Данзан гуай дурсан ярьж байсан. Засмал боржингоор үзэсгэлэнтэй сайхан бүтээсэн энэ суварга нь өргөн олонд сүсэг бишрэл төрүүлээд зогсоогүй түүнийг бүтээгчийн ур ухааныг бахдах сэтгэлийг төрүүлж иржээ. Одоо энэ суваргын дээд тал нь нурж зөвхөн суурь нь үлдсэн бөгөөд түүх соёлын үнэ цэнийг ухаарч хойч үедээ үлдээхийг мэдэхгүй хувьсгалч төрхийг харуулах гэсэн мунхаг харалган хүмүүс байсны гэрч болон харагдаж байна. Үлдсэн суурины эс, эд болох боржин чулуу нь бүтэн эвдэрхийгээрээ энд тэнд хэвтэж байгааг харсан хүмүүс ихэд гайхаж харамсдаг юм билээ.

1938 онд Сэлэнгэ аймгаас Булган аймаг салж анх байгуулагдахад аймгийн төр, олон нийтийн байгууллага, айл өрхүүдийн модон барилгуудын суурь эвээсэнд цагаан суваргын боржин чулууг мөн ч их хэрэглэсэн дээ хөөрхий. Одоо Цагаан суваргыг сэргээн босгох их ажил эхлэхэд Булганчууд ихэд билэгшээн баярлаж хандив тусламж өгч эхэлсэн. Аав ээжийн минь амьдарч байсан нутаг бэлчээр, миний чарлаж уйлж унасан, баярлаж инээж боссон эх газар нутаг минь учир би хандивт 200.000 мянган төгрөг өргөсөн. Цагаан суварганы урд талд нь шаттай модон саравчин дотор том боржин чулуун цөгцөнд зул байнга бадарч байдаг. Ээж минь намайг дагуулж очин зуланд шар тос өргөн

суварганд сунаж мөргөхөд би дагаж мөргөдөг байсныг сайн санаж байна. Ер нь хавар намарт одоо бодоход бурхан багшийн дүйцэн өдрөөр Майдарын голын урд гэнэтхэн л гэр майхан олширч, сүсэгтэн мөргөлчид ирж Цагаан суваргыг тойрон сунаж мөргөцгөөнө. Суваргын ар тохойд зусаж, намарждаг айлын хүүхдүүд бид суварган дээр гарч мөргөлчдийн цацаж өргөсөн мөнгийг түүж Вангийн хүрээний зах зээлийн дэлгүүр пүүсэнд очиж атга дүүрэн чихэр, танзуур овч идэхэд их амттай сайхан байдагсан. Харин суварган дээгүүр явахад шарилж мод нь хөл хатгаж өвтгөх, зулын тосыг нь амсахад их гашуун байсан нь санаанаас гардаггүй юм.

Гурав. Наян тохой Майдар бурхан

Дайчин Вангийн хүрээ олон зуун жилийн түүхтэй. Түүний гайхамшигтай шүтээнүүд нилээд эрт бүтээгдсэн юм билээ. Да хүрээний 80 тохой Мэгжид Жанрайсаг бурханыг 1910 онд бүтээж байсан бол Вангийн хүрээний Наян тохой Майдар бурханыг 1867 онд бүтээн босгосон гэдэг. Майдарын сүм нь Диваажингийн баруун хойно Домын хөтлийн урд талд байсан. Наян тохой Майдар бурхан нь сүмийн оройн цонхоор харагдаж байсан гэдэг. Одоо түүнээс юу ч үлдээгүй учир тийм сайхан шүтээн байсныг мэдэх хүн ховор болж дээ. Ийм том Майдар бурхан Монголд хэд хэд байсан гэж түүхчид бичсэн байдаг.

Вангийн хүрээний том цогчин дуганы өмнө жил бүрийн зуны адаг сарын эхээр цам харайх, Майдар эргэх их хөлийн наадам болоход дөрвөн дугуйтай модон тэргэн дээр ногоон модон морь хөлөглөсөн Майдар бурхан заларч, түүнийг тойрон зогссон лам нар арц хүж уугиулж тэнгэр бурхан, сүсэгтэн олонд арцтай тариа будаа цацан өргөж шашны хүндэтгэлтэй ёслол үйлддэг. Майдар бурхантай тэргийг сүсэгтэн олон ихэд хичээн түрж явдагсан. Тэрэг түрэлцсэн хэний ч бай тэр жилийн буян хишиг аривжиж нүгэл хилэнц арилж, өрх гэрийн хүмүүс ханиад эмгэг, өвчин зовлонгүй байдаг гэж үздэг. Майдар бурханы дуган сүмтэй суурин нь том жижиг гурван дугантай, лам нарын гэрт-байшинтай жижигсуурин байсан. Гол дуганы өмнө нарны сүүдрэвч шиг бүхээгтэй цэвэрхэн устай гүн худагтай. Худагийн эргэн тойрон чулуу шигтгэж зассан цэвэрхэн талбайтай. Мөргөлчид маш их очдог байсан. Харин хэлмэгдүүлэлтийн үед тэр сүм дуганыг буулгахад тэр худаг руу ном, бурхан их л хийсэн гэж хожим ярьдаг байсан.

Майдарын сүм Диваажинд ойрхон дэвсгэг газар байрласан болохоор өглөөний нарны гэрэлд дуган сүмийн алтан ганжир орой нь наранд гялалзаж, шар жанч орхимжтой лам нар өглөө хуралдаа морилон ирж байгаа нь хонь, үхрээ тууж явахад их л тод харагддагсан. Манайх энэ суурингийн баруун дэнж дээр хаварждаг байлаа. Ээж өглөө бүр Булган хангай уул, хүрээ хийддээ цай сүүнийхээ дээжийг өргөдөгсөн. Тэр ёс заншлыг нь одоо би дагаж явна. Одоо тэнд дуган сүм байсан гэх ул мөр юу ч үгүй, атаршсан газар болсон байна билээ.

Вангийн хүрээний бурхан шүтээний ийм хосгүй сайхан бүтээл түүх дурсгалын үнэ цэнийг ухаардаггүй, харалган ойворгон хүмүүсийн уршигт ажиллагаанаас нурааж устгагдсан. Үлдсэн хана, суурь эд хэсэг нь тэр хүмүүсийн балгийн ул мөр болон үлдэж үүний цаана хэн буруутай вэ гэсэн асуултад ганцхан 1930 хэдэн он гэдэг хариулт хэлдэг болж. Гандан хийдийн, урлагийн гавъяат зүтгэлтэн, шашны дээд сургуулийн багш гавьж асан Д.Данзан гуай Булганчууд сэтгэл зүрх гаргавал Диваажин, Өндөр цагаан суваргыг барьж болно би тусална гэж ярьж байсан. Өнөө үед Булганчууд Өндөр цагаан суваргаа босгох их буянтай үйл эхлүүлжээ. Төрсөн газрынхаа уул ус, унаган нутагтаа сэтгэл зүрхээрээ холбоотой хүмүүсийн нэгийн хувьд би Булган хангай нутаг Вангийн

хүрээний хийдийн тухай эрдэмтэн судлаачдын бүтээл, цуглуулсан материалаа ашиглан Диваажинтай төрсөн нутаг минь дурсамжийн номондоо бичсэн. Монгол орныхоо соёл, түүхийн хойноос мөр хөөн аялагч бүхэнд сонирхолтой байх болов уу гэж найдахын ялдамд ах дүү, хамаатан садан, үр хүүхэд, ач ачинцар, зээ, зээнцэр нар минь унших байх гэж бодно.

Дөрөв. Тамгын толгой

Хуучнаар Вангийн хүрээний хороо захын зүүн хойт талд одоогийн аймгийн баруун урд талын жижиг толгойг Тамгын толгой гэдэг. Харахад жижиг боловч улиран өнгөрсөн он жилүүдийн түүхийг хадгалсан болоод тэр үү одоо ч Тамгын толгой гэж нутгийн хүмүүс их л сүслэн биширдэг юм. Хувьсгалын өмнө ба дараах он жилүүдэд Булганхан уулын хошууны тамгын газар энд байрлаж, хошуу засаг захиргааны алба төвлөрч байснаас гадна ардын хувьсгалын партизанууд энэ толгой дээрээс Хүрээнд орогнож байсан цагаантнуудын байрлалыг сэм тагнан, ажиглаж хараад дайрч орон хүрээг чөлөөлж байсан түүхтэй. Мөн Сэлэнгэ аймгаас Булганхан уулын хошуу Дайчин Чин Вангийн нутгийг салгаж, Булган аймгийг анх байгуулахад мөнхүү толгой дээрээс харж анхны ерөнхий байршлын зургийг гаргаж байсан гэлцдэг юм билээ. Ер нь тэр үед Вангийн хүрээг эндээс харахад хүрээ ба хороо зах сайхан харагдаж байсан. Одоо хойч үеийн нутгийн залуучуудад Тамгын толгойн тухай учир байдлыг сайн ойлгуулбал уламжлал мартагдахгүй юм.

Ачуутын голыг боож уулын бэлээр өгсүүлэн татсан шуудуугаар урссан ус Тамгын толгой дээгүүр дамнан, хороо захын ногооны их талбай руу урсаж тэнд суурьшсан хятад, орос, монгол хүмүүсийн тарьсан ногоог усалж тэр хүмүүсийн амьдралыг тэтгэж байсан. Тэр үед хороо захын хүмүүс мах ногоо их зардаг. Тэднийг захын баячууд гэдэг байсныг сайн санаж байна. 1936 онд Тамгын газрын дэргэд Булганхан хошууны анхны бага сургууль байгуулагдаж шинээр барьсан модон дүнзэн байшинд хичээллэж, гэрүүдэд хүүхдүүд сууж, цай хоолоо иддэг байсан. Тэр үед бага сургуульд орсон хүүхдүүдийг заавал хүүхдийн байр гэрт оруулдаг байлаа. Гэр орон, эцэг эхээсээ холдож үзээгүй хүүхдүүд шөнө зүүдэлж босон харайж уйлж дуулах энүүхэнд. Би ахыгаа дагаж, уйлж байж сургуульд орсон болохоор ахтайгаа байнга хамт унтана. Харин сүүлдээ намайг модон орон дээр тусад нь унтуулж, бүсээр даруулж бөхөлж уядаг байж билээ. Тэгэж л ганцаараа унтаж сурсан юм.

Сургуулийн хүүхдүүд бараг нь төвийнх болохоор хэд хоног хичээллээд л гэртээ харина. Гэртээ ирэхэд ээж минь маш их баярлаж даавуун алчууранд боосон дөрвөлжин ёотон, улаан чавга, мөсөн чихэр аяганд хийж өгдөгсөн. Гэртээ ирэхэд хичнээн сайхан байдаг гэж санана аа. Би бараг ээжийнхээ өврөөс гараагүй байсан даа. Харин сургууль руугаа буцахад ах бид хоёрыг ээж маань хүргэж өгдөгсөн. Бид байшин гэрт хуваагдаж хичээл хийнэ. Манай ангийн багш Янжмаа гэж сайхан зан ааштай, ухаантай дөлгөөхөн эмэгтэй хүн байлаа. Бидний толгойг байнга л илдэгсэн. Хуучин монгол үсэг үгийн эхэн, дунд, адагт бичихдээ ацаг шүдний зөрүүтэй тул үсэг тоо сургах гэж их л зовдог байсан даа. Бид 3-р ангидаа сайн уншиж бичиж чаддаг болсон. Үржүүлэхийн хүрдийг гараар дохиж, зэрэг чанга чанга хэлүүлж цээжлүүлж байсан нь сургах нэг арга байсан байжээ. Бид ч үржүүлэхийн хүрдийг амархан цээжилсэн. Бидэнд пионерийн дуу зааж, дуулуулдаг байлаа. Өдөр бүр л бүх хүүхдийг жагсааж улаан бүч зүүлгэн дуу дуулуулж, бөмбөр цохин бүрээ үлээлгэж муур хулгана болгон тоглуулж, хоёр гурван эгнээгээр зогсоож улаан дарцаг бариулан уралдуулах зэргээр тоглуулна.

"Том баяр болно, та нар очиж тоглоно, хүмүүс үзнэ, тиймээс тун хурдан

сайн тоглоно шүү" гэж захирал Агваанбалдан багш бидэнд ярьж захиж байлаа. Тэгээд удалгүй бид жагсаж дуугаа дуулж, бөмбөрөө цохин Тамгын толгой руу бууж эргэн тойрон хашаатай, урд тал нь онгорхой хагас дугуй хэлбэртэй байшинтай хашаанд орлоо. Тэнд маш олон хүн цугларч, морьтой хүмүүс давхилдсан, дуу хөгжим хангинаж, бөх барилдаж байлаа. Хожим бодох нээ голын цэнгэлдэх газрын нээлтэнд хүүхдүүд биднийг оролцуулж байсан нь тэр байж. Тэгэхэд бидний жагсаал, тоглоом наадмыг хүмүүс ихэд сонирхон үзэж байсан юм. Одоо тэр голын цэнгэлдэх хэвээр байгаа. Харин засаж тохижуулж Булган хотынхон тоглоом наадмын газар болгосонд их баярлаж явдаг даа.

Энэ газрыг "Голын цэнгэлдэх" гэж нэрлэснээр одоо тэр нэр хэвээр үлджээ. Цэнгэлдэхийн дэргэдүүр Ачуутын гол урсдаг учир Голын цэнгэлдэх гэж нэрлэсэн бизээ. Тэр цэнгэлдэхийн урд талд гол дагаж айлууд зусаж унагаа уяж, гүүгээ сааж, тогоо нэрж, өрөм ааруулаа хурбааж, налгар сайхан зусаж намарждагсан. Хөгшид эрчүүд айл хэсэж айраг шимийн архи ууж, дуу аялж, зарим өдөр найр болж хүмүүс сэтгэл санаа амар тайван баяр хөөртэй байдагсан. Энэ ч хангай нутгийнхны заншил юм даа. Нэг айлаас нөгөө айлд бууж мордоод л явж байдаг. Харин залуучууд нь гүү сааж байвал унага татаж өгнө. Голын цэнгэлдэх дотор гол дагаж цахилдаг их ургана. Хүүхдүүд усанд орж, мөлхөж, нуугдаж, байлдаж их тоглоно. Тэгэхэд бидний хөл гар, цээж нуруу цахилдаганд урагдаж шалбарах нь амархан. Гэрийнхэн маань үзээд загнадаг ч бид тоодоггүй, ингэж тоглох нь урамтай сайхан байсан байх.

Нэг өдөр цэнгэлдэхийн дэргэд бидний усанд ордог газар машинтай орос, монгол хэдэн хүн ирж тороор загас шүүж байхыг бид зайдуухан зогсож байгаад сонирхон харж байлаа. Тэд жижиг төмөр лаазтай юм идэж, чанасан гэдэс шиг юм барьж хальсалж иднэ. Хүүхдүүд биднийг дуудахад бид эмээж холхоноос харж явахыг нь хүлээлээ. Тэднийг явмагц очиж үзэхэд дугуй төмөр лааз, гэдэсний хальс хаясныг нь ихэд сонирхоцгоож лаазны доторхыг үнэрлэхэд эвгүй үнэртэж байсансан. Бидний зарим нь барьж үзэхээс ч айн цэрвэж холхоноос харж байж билээ. Хожим бодоход лаазалсан загасны мах, утсан хиамны хальс байж дээ. Тэр үед тийм хүнсний зүйл байдаг гэдгийг хөдөөний багачууд бид яаж мэдэх вэ дээ.

Тав. Радио гэгчийн дуу хоолойг анх сонссон минь

Засагт хан аймгийн Дайчин Вангийн хошууны төв нь Вангийн хүрээ гэж их том суурин байлаа. Одоогийн Булган аймгийн төвийн зүүн урд талд юм даа. Тэр үед Богдын хүрээнээс гарсан их аяны зам Вангийн хүрээний суурины дундуур гарч, Тамгын толгойн урд талаас хойш эргэж одоогийн аймгийн төвийн дундуур дайран Хөвсгөл нутгийг чиглэдэг байсан. Энэ төв замын баруун хэсгийг Хүрээ, зүүн хэсгийг хороо тал гэж нэрлэдэг байсан. Одоогоос 10 орчим жилийн өмнө энэ суурингийн төв хавьд хятдын пүүсийн том саорал байшингийн дэргэд төв замын хажуугийн утасны модонд нэг өдөр хөлөндөө дэгээ гинжтэй хүн авирч гараад дугариг хар далбигар таваг бэхэлж уяад явчихлаа. Хүмүүс үүнийг араажав (радио) гэдэг юм. Үүгээр хүн ярьж, дуу дуулж хөгжимдөнө гэгцгээж байлаа. Харин үүний ойр янз бүрийн юм ярьж, дуугарч болохгүй шүү гэх яриа ч сонсогдоно. Тэр жил манайх малгүй, ээжийн дүүгийн хашаанд өвөлжиж байлаа.

Гэтэл нэг өдөр тэр араажавын дэргэд морьтой, явган маш олон хүн цугларсан харагдана. Очтол нөгөө дугариг хар араажаваар хүн ярьж, дуулж, хөгжимдөхөд хүмүүс ч гайхах сонирхож зэрэцэн зогсоно. Тэгээд хэд хоногоос томчууд нэг их анхаарахаа больсон. Харин хорооны хүүхдүүд радиогоор хүн ярих, дуулахыг сонирхож тэнд тоглож өнждөг боллоо. Ингэж Дайчин Вангийн

хүрээнийхэн радиогийн дуу хоолойг анх сонссон түүхтэй. Түүнээс хойш удалгүй радиотой шонгийн модны дэргэд чанга дуугарч ярихаас ихээхэн эмээдгийг томчуудын ярианаас сэм сонсож билээ. Нэг өдөр манайд ирсэн Гэсэрийн Төр гэдэг өвөө цай ууж суухдаа ээжид "за хө Цэнд минь танайх энэ дугариг хар юмтай утасны модонд ойрхон байдаг юм байна. Одоо цаг зэвүүн болж байна. Танайхаар таних танихгүй хүн, авгай хүүхдүүд бишгүй л орж гардаг байх. Илүү дутуу үг битгий ярьж байгаарай. Үг яриа хэлэлцэх, ярих ажил гарвал яндангаа буулгаж байгаад ярьж байгаарай. Бидний яриаг энэ араажав гэдэг дугариг хар юм чинь яндангаар дамжуулж татаж аваад төв рүүгээ дамжуулдаг юм гэнэ шүү" гэж ихэд чухалчилан захиж байсныг санадаг юм. Тэр үед шашин шүтлэг хэвийн дуган сүм сайхнаараа байсан боловч удалгүй хэлмэгдүүлэлтийн хар шуурга дэгдэж, лам хуваргуудыг баривчилж, дараа нь дуган сүм суваргыг нурааж, тонон дээрэмдэж түүх дурсгалын асар их бүтээлийг үгүй хийсэн юм. Энэ бүх ажил олны нүдэн дээр ил явагдаж байсан болохоор сүсэпэн олон их л харуусаж зовж шаналж байсан бизээ.

Радио нэвтрүүлгийн дуу хоолойг багадаа анх сонсоод гайхаж байсан бол оюутан ахуй цагт миний амьдралд радио нэвтрүүлэг их тус болсон санагддаг. 1950-иад оны үед Сүхбаатарын төв талбайд байрлуулсан радиог бид цагаан хоолой гэж нэрлэдэг байлаа. Би оюутны дотуур байранд суудаг. Оюутны байр тэр үеийн ХДТеатрын зүүн хашаанд байдаг тул төв талбайн радиогоор өглөөний нэвтрүүлэг эхлэхэд бид босож цайндаа ороод хичээлдээ явна, ирнэ, оройн давтлагадаа очно, ирнэ. Энэ бүхэнд радио л тусалдагсан. Учир нь радиогоор цаг байнга зарлана. Төв талбайн радиогийн дуу хоолой тод чанга байсныг тэр үеийн хүмүүс сайн мэднэ дээ.

Зургаа. Жасын нярвынх

Миний аав Төрийн Чойжамц гэдэг хүн байсан. Вангийн хүрээний Цогчин дуганд няравын албатай хуварга хүн байлаа. Аав ээж хоёр минь дөрвөн хүүхэд төрүүлсэн. Би дээрээ хоёр эгч, нэг ахтой айлын отгон нь. 1929 оны гал могой жилийн хаврын тэргүүн сард Булган хангай уулын үргэлжлэл Шар чулуут уулын өвөрт төрсөн. Тэнд миний хорвоод мэндэлж хүй цэглэсэн бууц минь бий. Ой мод, ан амьтан, жимс ургамлаар элбэг баян Булган хан уулын баруун суга хөндий, Чандагатын хөтөл, Майдарын гол, Өндөр цагаан суварганы өргөн дэнж зэрэг газарт жилийн дөрвөн улиралд манайх нутаг сэлгэн бууж ах дүү, нутаг нугынхантайгаа хаяа дэрлэж айлсаж, малаа маллаж, сүү цагаан идээ, айрагундаагаар элбэг тэнүүн сайхан нутаглаж байсан санагддаг.

Аав жасын няравын ажилтай тул жасын мал малладаг малчид айл саахалт ойрхон байсан байх. Хүмүүс манайхыг жасын няравынх гэдэг байсан гэж багад ээж маань ярьдаг байсан. Дуган сүмд өдөр бүр лам хуваргууд ирж хурал хурж, ном уншдаг учир манж, цав барьж, цайлж хооллоно. Иймд жасын олон малыг хариулж малладаг айлууд голдуу Майдарын голд нутаглана. Ийм хүмүүс дуган сүмдээ их шүтлэгтэй. Аав жасын малчин айлуудаар явж мал хөрөнгөө харах, мах сүү айраг цагаан идээ цуглуулж үхэр тэргээр зөөж, сүмдээ авч ирэх албатай. Би тэргэн дээр нь сууж хамт явдаг. Хааяа дуган сүмдээ сууж хурал номын ажилд оролцдог байсан байх. Харин намрын хайлан хурах хуралд байнга суудаг байсан гэж сонссон. Аавын төрсөн дүү Ням гэдэг эмэгтэй алдартай удган байсан. Тэр үед удган бөө нар орой үдэш л бөөлнө. Энэ орой нь тэр хотын айлууд малаа хашин, гэр ахуйн ажлаа цэгцлэн удганы гэрт цуглардаг байж. Удганы онгод ороход хүмүүс уул ус, мал сүрэг, бие сэтгэлээ даатгаж ариусгах, сүлд хийморио сэргээж даатгуулах, аян замынхаа саад зэтгэрийг арилгуулах зэрэг засал хийлгэдэг байсныг сайн санадаг юм. Энэ нь удган бөө бөөлөх тэр үеийн ёс жаяг юм. Авга эгч Ням

манай том эгчийг өргөж авсан болохоор гэртээ үлдсэн эгч, ах бид гурав ээждээ гэр ахуй, мал маллах ажилд тусална. Миний ээж нуруулаг, махлаг биетэй нутгийн хүмүүс "Бүдүүн Цэнд" гэдэг байсан. Харин ажилд эрэмгий чадалтай, нүүх, ачилга, түлшинд явахдаа хүний царай хардаггүй хүн байв. Айл саахалтын хүмүүс ойр зуурын ажилд манайхаас үхэр тэргийг маань гуйдаг байсан. 1934, 1935 оноос монгол орныг ширүүхэн нөмөрсөн гадны түлхээсийн хэлмэгдүүлэлтэд аав маань өртсөн. Цогчин дуганы хамгийн том ламыг ловон багш гэж хүмүүс хайрлаж шүтдэг байсан. Нэг өдөр ээж хоол цай хийж аав ловон багш хоёрт өгөхөөр хоригдож байсан газар луу нь явж байсныг тод санаж байна. Заримдаа ээжээс аавыг асуухад: аавыг мөд ирэхгүйг ойлгуулж, санаа алдан, хааяа сэмхэн уйлж байсныг нь мартдаггүй юм. Харин ээж маань хааяа зул өргөж, арц уугиулж, судар ном тэвэрч гэр, хотоо тойрч гороолдог байсныг сайн санадаг.

Ааваас хойш бидэнд олон малын ажил ахадсан тул ээж өөрийн төрсөн дүү Амгаландаа малаа хагаслан өгч, аминдаа жижиг цөөн мал, нүүдэл суудал, аргал түлшинд явах гурван модон тэрэгтэй үлдсэн гэдэг. Тэр тэргэн доор сүүдэрт нь манай "Түүтгэр" хэвтэж байдаг. Айхавтар зуумтгай нохой байсан даа. Ээжийн дүү Амгалан нь хүнд тусархаг сэтгэлтэй, нутагтаа нэр хүндтэй, танил тал сайтай, чинээлэг, мал хөрөнгөтэй Сээрийнхээ нутаг голдоо нэртэй малчин хүн байсан юм.

Ээж хааяа хоёр үхэр тэргээ хөллөж хөтлөөд ах, бид хоёрыг дагуулж Шар чулуут уулын баруун суганд очиж хуурай гишүү түүж аваад гаднаа буулгаж түлшиндээ хэрэглэдэг. Заримдаа хороо зах орж, махны худалдаачдад өгч гэдэс, толгой, шийр, өвчүү, хошного авч ирэн чанаж хоол хийхэд айл саахалтынхан ирж тусалцан шөл ууж, хооллон, хүүхдүүдэд шийрийг нь хувааж жаахан гэдэстэй өгөхөд цөм ихэд баярлацгаадагсан. Арга ч үгүй биз тэр үед зун, намарт махан хоол бараг идэхгүй, сүү хөөрүүлж, тараг ууж, ааруул ээдэм идэж хонодог уламжлалтай байсан. Тэр шийр гэдэсний сайхан амттайг яана аа... Миний ах Бадрах надаас нилээд хэд ах, эгч Баасанхүү сургуульд ороогүй ч ээжид тусалж, гэр малын ажил хийдэг байсан.

Харин бага сургуульд байхад ах маань сургуулийн цагирган савлуураас унаж бэртээд осолдсон. Ээж удалгүй нас барж, эгч бид хоёр өнчирч үлдсэн. Тэгэхэд ээжийгээ л их санан үгилж байсан. Амьдрал үргэлж сайхан тэгш байдаггүйг ойлгож мэдэрсэн ч, ингэж хатуу хандсанд гомдох тусам өдрөөс өдөрт хатуужиж байгаагаа мэдэрч, сэтгэлийн хат суудаг юм билээ. Ээж амьд сэрүүн байхдаа ааваас хойш биднийг аавын дүү Жалбуугаар овоглуулж үлдээсэн. Жалбуу нь ардын хувьсгалын партизан нэр төртэй хүн байсан юм даг. Харин би газардаагүй. Том эгчийн нөхөр Надмид ах намайг татан авч офицерийн сургуульд оруулж боловсролтой болбол бие дааж амьдарч чадна гэж захидаг, намайг хайрладаг буянтай, амьдрах ухаан сайтай хүн байсан. Ах цэргийн газар удирдах ажил хийж байгаад саналаараа чөлөөлөгдөж хувийн аж ахуй эрхэлдэг болсон. Түүний гэргий миний эгч Сүръяаг аавын төрсөн дүү Ням удган багад нь үрчилж авсан юм. Тэднийх Богдын хүрээнд олон жил амьдарсан болохоор эгч цэвэрч нямбай, төлөв даруу хүн болж хүмүүжсэн. Ахынх найман ханатай гэртэй, 5 хүүхэдтэй өнөр сайхан айл байсан. Эгч гэрээ маш цэвэр цэмцгэр байлгаж, орнуудаа маш сайхан бүтээж засаад хүн суулгахгүй гэж урдуур нь орны толгойг холбож утас татчихдагсан. Ах бид нар гаднаас орж ирээд гутлаа тайлж зуухнаас дээш сууна. Гуталтай бол зуухнаас дээш гарахгүй. Гадны хүн орж ирээд суух жижиг сандал, ширээ баруун талд нь байдаг байлаа.

Харин манай оронд социалист систем ид цэцэглэж хувийн өмчийн эсрэг

үзэл давамгайлж байсан 1950-иад оны үед ахынх хувьдаа саалийн хэдэн үнээ, өндөглөгч 150 гаруй тахиатай хуучнаар тавын халуун усны урд талд хашаанд байсан. Ер нь тэнд хувийн аж ахуйтай, эрлийз сайхан том морь, луус хөллөсөн усчин хятад мойгол айлууд олноор суурьшсан байсан. Эгч ах хоёр ажилсаг, хүнтэй эвтэй, бусдад тусархаг, тэр орчиндоо нэр хүндтэй хүмүүс байсан даа. Ахынх номхон нэг луустай. Эгч луусаа тэргэнд хөллөөд сүү таргаа сүүн захад очиж, сүүний даамалд өгчихнө. Өндөгөө хятад, оросуудад өгдөг. Энэ ажилд нь айлын хөршүүд тусалдаг байлаа.

Хувийн аж ахуйтай албан хаагч нь тэр үеийн бодлогод нийцээгүй учир ах маань Гадаад Яамны газрын дарга, Намын Дээд Сургуулийн сонсогчийн ангиас хасагдсан. Тэгэхэд эгч маань нилээд бухимдаж "Манайх хувийн аж ахуйтан байх эсэхийг төр заахгүй. Бид аж ахуйгаа яаж цэгцэлж ажиллахаа мэднэ. Үхэр, тахианыхаа ачаар хоол ундтай, хүний гар харахгүй хүүхдүүдээ тэжээж хувцаслаж байна. Харин манайхыг баян помещик гэдэг нэр өгсөн гэсэн. Тэр үгийг нь хүмүүс яаж хүлээж авдаг юм бүү мэд" гэж хэлж байж билээ. Түүнээс хойш ах эгч хоёр маань хувийн аж ахуйгаа эрхэлсээр насаа элээсэн дээ. Харин ах эгч хоёр энх тунх байхдаа 1988 онд бид хоёрт "Сэлэнгэ" үүлдрийн тугалтай үнээ өгөхөд их баярлаж, аав ээж, ах эгч нарын жишгээр үхэр маллаж, ногоо тарьж үр хүүхэд, ах дүү нартаа буян хишгийг нь тарааж байлаа даа.

Ах төрийн ажлаа өгсөний дараа сэтгэл санаагаар унаагүй, харин ч одоогийн заншлаар бизнес эрхэлж орлого сайтай байсан. Удалгүй Барилгын Яам дуудаж 1957 онд Сэлэнгэ аймагт Дулаан хааны модны заводын даргаар томилон ажиллуулж билээ. Тэнд очоод ажлаа сайн зохион байгуулж, мод бэлтгэх төлөвлөгөөг жил дараалан биелүүлж, социалист уралдаанд түрүүлж шагнуулж байсан юм. Ер нь ах ажилдаа их санаачилагатай болохоор удирдлагатайгаа зохицож, Улаан-үд, Эрхүү хот орж албан газартаа хэрэглэх барилгын материал авч наймаа хийж буриад ажилчид авчирч албан контор, ажилчдын орон сууц, соёл үйлчилгээний төв зэрэг халаалттай барилга бариулж соёл, хүмүүжил, үзвэр үйлчилгээний ажил явуулдаг клубтэй болгосон. Тэгэхэд тэндхийнхэн хүмүүс ихэд баярлаж ажлыг нь дэмжиж сайхан сэтгэлээр хандаж байсан гэдэг. Ах Надмид хүнд их тусалдаг, амьдрал ахуйг нь их дэмждэг ажилд зарчимч хүн байсан. Одоо бодоход бизнесийн ухаан сайтай хүн байжээ.

Одоо ч тэндхийн настангууд ахыг ажилчиддаа яаж тусалж байсан тухай их дурсан ярьдаг юм билээ. Хэдэн жилийн өмнө тэр тосгоноор өнгөрөхдөө тэндхийн ажилчдад бариулж өгсөн модон дүнзэн байшинг харахад хүмүүс улам сайхан засаж тохижуулсан, нэмж олон сайхан барилга барьсан, ихэнх айлууд нь үхэр малын саравч, ногооны хашаатай болж жимс төрөл бүрийн ногоо тарьсан байгаа нь тун сайхан харагдаж байсан шүү.

Ээжээ дурсахуй

Хөдөө хээрийн үзэсгэлэнт саран байсан та
Хүү наддаа үүрдийн наран болж мандсан та
Хүндлүүлж хайрлуулах байсан эх минь та
Хүү надтайгаа үдэлж амьдраад буцсан та
Хөдсөн нэхийд манцуйлж, намайг бүүвэйлсэн та
Хөхнийхөө уураг, сүүгээр тэжээж намайг өсгөсөн та
Хөрст дэлхийн шороон дээр хөлийг минь гишгүүлсэн та
Хүлэг морины дэлнээс гарыг минь атгуулсан та
Хүний нийгмийн амьдралд хөтөлж оруулсан та
Хүн зон олонтой мэндлүүлж сургасан та
Ээж таныхаа өгөөмөр их ачийг
Юутай зүйрлэхээ хүү би даанч олсонгүй
Зүүд зөн совинд даан ч бууж ирсэнгүй

Бодоод бодоод бодол ухаан минь хүрсэнгүй
 Огторгуй баганадсан өндөр сарьдаг уулсын
 Оргилын өндрийн өндрөөс ч дээш байж таарна
 Нүд алдам сүн их гадаад далайн
 Гүн ёроолоос ч доош байж таарна
 Огторгуйн уудам хязгаарт ч
 Очоод олохгүй оюун номин эрдэнэ болов уу
 Огторгуйгаас буусан хурын шүүдрийг
 Цэцэг ургамлаас түүж аваад
 Цангаа гаргах аяга цай чанаж
 Ээж таны өлмийд мэхийн мөргөж
 Алтан аяганд хийж барихад
 Ачийг хариулдаг гэдэг мэргэдийн сургаал
 Ай даа магад үнэнд нийцэх болов уу, яах бол
 Зон олон та бүхэнд зориглон хандахад
 Ээжийн сэтгэлийн гэгээн хайр
 Насан туршид мөнхөд орших болтугай.

Төрж өссөн нутгийнхаа тухай дурсан бичиж байхад эцэг, эхийн гэгээн хайр санаанд бууж, ээжийн ач буянг мартахын аргагүйд хэдэн мөрийг үзэглэн буулгалаа.

Сонгино хайрхан уулыг анх тахиулсан минь

Нийслэл хотын баруун талд онгон сарьдаг Сонгинхайрхан уул байдаг. Энэ уул нь ой модгүй боловч хад асга ихтэй өндөр сүрлэнг уул юм. Урьд талаараа тунгалаг Туул голыг дагасан бургас, хайлаасын их шугуйтай. Ар талдаа хус модны жижиг төгөл цардуултай. Харин туулай, үнэг, чоно элбэгтэй. Урьд цагт галт хар үнэгтэй байсан учир өвөлд цасгүй байдаг (Г гэсэн домогтой. Сонино хайрханы өвөр, хатан Туул голын хөвөөнд мартагдашгүй он жилүүдийг элээн суурьшсан улсын мал эмнэлгийн түүхэнд Сонгины Биокомбинат гэдэг үйлдвэр байдаг. Түүний хүч бүрэлдэхүүн нь тосгоны уугуул хүмүүс. Сонгино хайрхан уул нь онгон догшин учир нутгийнхан нэрлэхээс цэрвэж зөвхөн Хайрхан гэж шүтэж сархад, цайныхаа дээжийг цацал болгон өргөдөг заншилтай. Сонгино хайрханы савдагын эзэн нь хөх үхэр унасан, араа соёо нь зөрсөн цал буурал үстэй, турьгүй чөргөр биетэй сархаданд их дуртай энэрэнгүй сайхан сэтгэлтэй, нутгийнхандаа тустай ч санаа сэтгэл нь үймэрвэл дэлхийг хөдөлгөж хүн олноо сандаргадаг гэж ярих нь үнэнтэй. Энэ уулын тухай эрт цагт их хүрээний нэг эрдэмтэн лам Лувсан-Пэрэнлэйжамц Сонгино хайрханы магтаал сан сэржим өргөх ном зохиолдоо ... танай тэр өндөр хар уул чинь сүрхий догшин уул байна. Хатуу үйлийг захиж хүсэхэд хэргийг чинь түргэн бүтээх уул юм байна. Энэ уулын эзэн заримдаа их цэргийн ноёны байдалтай ч болдог ид шидтэй өвгөн байна шүү гэж айлдсан домог байдаг.

1990 онд ардчилсан хөдөлгөөн гарч төр засаг өөрчлөгдөж Монголчууд эрх чөлөөтэй болж, хуучны зан үйл шүтлэгээ сэргээж уул овоогоо дахиж эхэлсэн. 1992 онд Сонгино хайрхан уулыг дахиж уул овоогоо сэргээе гэдэг санал бодлоо Био үйлдвэр, тосгоны хороо захиргаанд танилцуулахад дуртай зөвшөөрч, тосгоныхон ихэд сайшаан дэмжсэн юм. Тэр үед хөгшид залуучууд, хүүхэд Сонгино хайрханаа тахих ажлыг сонсоод ихэд байрлаж байж билээ. Арга ч үгүй биз дээ. Уул усаа тахих ажлыг мэдэхгүй анх сонсож байгаа нь энэ. Би тэр жил Гандан, Зүүн Дашчойлон, Ламиран хийдүүдийн зурхайч нараас овоо тахих өдрүүдийг асуухад V сарын 26-ны өдрийг өлзий буян хишигтэй сайхан өдөр гэж хэлж өгсөн. Би багадаа овоо тахих ажлыг үзэж байсан болохоор бүтэн хонины шүүс, тавгийн идээг бүлтгүүлж морь уралдах, бөх

барилдах, уулын оргилд гарах, спорт тэмцээн явуулах зэрэг ажил зохиох. Энэ ажилд үйлдвэр, хороо захиргаа, тосгоныхон сайн оролцсон. Нэг өдөр үйлдвэрийн намын дарга дуудаж ирэх сайн өдөр VI сарын 3 нд үйлдвэрийн ажилчдын зугаалга болох тул хамтадгая гэж тахилгын өдөр өөрчлөгдлөө. Тэр өдөр хотоос овоо тахилгын лам авчирахад нартай тогтуун сайхан өдөр байв. Сонгино амралтын хойд дэнжид хүмүүс цугларч, асар майхан барьж, туг дарцаг босгож цэргийн хөгжим хангинаж сайхан наадам болох төлөвтэй байлаа. Харин бага зэрэг салхитай байснаа тэнгэр бүрхэж маш хүчтэй салхи гарч цасаар шүүрч майхан асарыг унагаж сандаргав.

Бид сандарч лам нараа авч уул өөд авирч, арайхийж гараад лам нар овоо тахилгын номоо уншиж, нөмөр нөөлөг барьж байж арч хүжээ уугиулж овоондоо сүү, цай, идээ, архиныхаа дээжийг өргөж уул савдагаа аргадаж мөргөөд уулнаас бууж билээ.

Бид тэндээс үйлдвэрийнхээ биеийн тамирын зааланд ирж лам нар овоо тахилгын номоо үргэлжлүүлэн уншиж, арч хүжээ уугиулж хүмүүст арч тариа, овооны хишгийг тараан өгч билээ. Тэр өдөр зөвхөн зурвас газарт цас орж шуурсан.

Тэгээд удалгүй гурван хоногийн дараа хайрхан уулын баруун дээгүүр бөөн хар бараан үүл гарч эгшин зуур их устай аадар бороо орж тосгоны урд талаас гэнэт бөөн үер бууж үйлдвэрийн подвал усаар дүүрч тосгонд ихээхэн хохирол учруулсан юм. Энэ бүх үйл явдал нь хайрхан уулыг дахих өдрийг өөрчилсөнөөс боллоо гэж тосгоныхон ярьдаг юм.

Ер нь хад асга ихтэй өндөр сүрлэг Сонгино хайрхан уул нь үнэхээр их догшин уул юм. Хайрхан уулын эзэн нь хөх үхэр унасан цал буурал сахал үстэй турьгүй чөргөл биетэй атлаа дургүй нь хүрвэл айхтар уурладаг хөх өвгөнөөр дүрслэгдсэн нь үнэн юм байна гэж ядуухан ухаан санаанд минь буусан юм.